ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 09 сарын 25 өдөр Дугаар А/270 Улаанбаатар хот

Цагийн хуваарийн зөвлөлийн бүрэлдэхүүн,
ажиллах журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх хэсэг, Цагийн хуваарийн зөвлөлийн ажиллах журмын 4.2 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цагийн хуваарийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-г хавсралтаар батлалсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Бат)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/24 дугаартай “цагийн хуваарийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай”, тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Г.БАТБАЯР

1712502 0918

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн
А/270 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Цагийн хуваарийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Иргэний нисэхийн ерөнхий газрын Төлөвлөлт зохицуулалтын газрын дарга

Гишүүд:
Иргэний нисэхийн ерөнхий газрын Иргэний нисэхийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Агаарын навигаци, аэродромын бодлого, төлөвлөлтийн газрын дарга

“Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн олон улсын нисэх буудлын гүйцэтгэх захирал /Зөвшилцсөнөөр/

“Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн олон улсын нисэх буудлын Үйл ажиллагаа хариуцсан захирал /Зөвшилцсөнөөр/

“Нью улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн олон улсын нисэх буудлын Нисэх буудлын үйл ажиллагаа, удирдлагын газрын дарга /Зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга: Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны дарга

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
А/24 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1.ЗОРИЛГО

1.1.Олон улсын болон орон нутгийн нисэх буудлуудын багтаамж үйлдвэрлэл, үйлчилгээний нэвтрэн өнгөрүүлэх хүчин чадал, агаарын тээвэрлэгчдийн тээвэрлэлтийн боломжтой уялдуулан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг нэгтгэх, батлах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

2.ТОДОРХОЙЛОЛТ

2.1."Хуваарьт нислэг" гэдэг нь олон нийтэд нээлттэй зарласан цагийн хуваарийн дагуу тогтмол давтамжтайгаар үйлдэх нислэгийг хэлнэ.

2.2."Нэмэгдэл нислэг" гэдэг нь хуваарьт нислэгийн цагийн хуваарьт тодорхой хугацаанд нэмэгдэх нислэгийг хэлнэ.

2.3."Түүхэн нислэг" гэж тухайн улиралд батлуулсан нэг чиглэлийн нислэгийн цагийн хуваарийг 80-аас доошгүй хувийн гүйцэтгэлтэй ашигласан ба дараагийн улиралд тухайн хуваарьт нислэгийн цагийг хадгалах эрхийг хэлнэ.

3.ЗОХИЦУУЛАЛТ

3.1.Нислэгийн цагийн хуваарийг олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарь гэж ангилна.

3.2.Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг Улаанбаатарын цагаар (+8GMT) тооцно.

3.3.Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн улирлыг Олон улсын агаарын тээврийн холбоо /IATA/-ноос тогтоосон хугацаанд мөрдөнө. Үүнд:

3.3.1.Олон улсын болон орон нутгийн зуны улирлын нислэгийн цагийн хуваарийг 3 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Ням гарагаас 10 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Бямба гарагийг дуустал.

3.3.2.Олон улсын болон орон нутгийн өвлийн улирлын нислэгийн цагийн хуваарийг 10 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Ням гарагаас дараа оны 3 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Бямба гарагийг дуустал.

4.ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛ

4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нисэх буудлуудад нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчдийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн төслийг энэхүү журмын дагуу хүлээн авч, Цагийн хуваарийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-өөр хэлэлцэн батална.

4.2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид "ИНЕГ" гэх/-ын даргын тушаалаар томилно.

5.ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

5.1.Зөвлөлийн гишүүн Олон улсын агаарын тээврийн холбооноос зохион байгуулдаг цагийн хуваарийн зохицуулах хуралд жилд нэгээс доошгүй удаа оролцоно.

5.2.Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хурлыг жилд 2 удаа зохион байгуулж өвөл, зуны улирлын олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэлэлцэн батлах бөгөөд Зөвлөлийн даргын шийдвэрээр ээлжит бус хурлыг хуралдуулж болно. Үүнд:

5.2.1.Өвлийн улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг жил бүрийн 9 дүгээр сарын эхний 7 хоногт.

5.2.2.Зуны улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг жил бүрийн 2 дугаар сарын эхний 7 хоногт.

5.3.Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хуралд Агаарын тээврийн холбоо болон агаарын тээвэрлэгч байгууллагуудыг оролцуулж болно.

5.4.Зөвлөл нь гадаадын агаарын тээвэрлэгчдийн олон улсын хуваарьт нислэгийн өвөл, зуны улирлын цагийн хуваарийн тогтмолжилт зэргийг харгалзан үзэж энэхүү журмыг баримтлан ажиллана.

5.5.Зөвлөл нь гадаадын агаарын тээвэрлэгчдийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн төслийг шийдвэрлэхээс өмнө үндэсний агаарын тээвэрлэгчдийн нислэгийн цагийн хуваарийг төлөвлөх, зохицуулах чиглэлийг баримтална.

5.6.Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

5.6.1.Олон улсын өвөл, зуны улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг батлах;

5.6.2.Орон нутгийн өвөл, зуны улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг батлах;

5.6.3.Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх;

5.6.4.Нисэх буудлын засвар үйлчилгээ хийхтэй холбоотой зохицуулалт хийх;

5.6.5.Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдал үүссэний улмаас нисэх буудлуудын үйлчилгээг тодорхой хугацаанд хязгаарлах асуудлыг хэлэлцэх;

5.6.6.Нислэгийн цагийн хуваарийн журамд өөрчлөлт оруулах;

5.6.7.Зөвлөлийн даргын шийдвэрээр яаралтай хэлэлцэх бусад асуудлууд;

5.7.Зөвлөлийн гишүүд нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгах асуудлыг холбогдох тооцоо, судалгаа, шийдвэрийн төсөл, бусад материалын хамт зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

5.8.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хурал болохоос 5 хоногийн өмнө боловсруулж, хэлэлцэх асуудлын танилцуулга, материалын хамт Зөвлөлийн даргад танилцуулж, урьдчилан батлуулсан байна.

5.9.Зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудалд агаарын тээвэрлэгчид олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэрхэн мөрдөж ажилласан болон гаргасан зөрчил дутагдлын талаарх тайланг тусгана.

5.10.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүн тус бүрд цагийн хуваарийн төслийн танилцуулга, судалгаануудын хамт Зөвлөлийн хурал эхлэхээс 2 хоногийн өмнө цахимаар хүргүүлж, танилцах, судлах боломжоор хангана.

5.11.Зөвлөлийн хурлын батлагдсан төлөвлөгөөний дагуу зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр танилцуулга хийнэ.

5.12.Зөвлөл нь Нарийн бичгийн даргын нэгтгэсэн цагийн хуваарийн төслийг хэлэлцэж батална.

5.13.Зөвлөлийн хуралд хэлэлцэж буй асуудлыг тодруулах, нэмэлт мэдээлэл авах зорилгоор дотоодын агаарын тээвэрлэгч байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг, гадаадын агаарын тээвэрлэгч байгууллагуудын ерөнхий төлөөлөгч нарыг оролцуулж болно.

5.14.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд төрийн чиг үүргийн байгууллагуудтай харилцан тохиролцож холбогдох зохицуулалтыг хийх зорилгоор хил, гааль, мэргэжлийн хяналт, гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

5.15.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулах ба Зөвлөлийн даргад танилцуулна. Хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг бүрэн тусгасан байна. Үүнд:

5.15.1.Хурлын байршил, огноо, бүрэлдэхүүн

5.15.2.Хэлэлцсэн асуудлууд;

5.15.3.Хэлэлцсэн асуудал тус бүрээр гаргасан шийдвэр.

5.16.Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга ажлын 3 хоногт багтаан журмын Хавсралт 2-ын дагуу батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

6.НИСЛЭГИЙН ХУВААРИЙГ ЗОХИЦУУЛАХ БОЛОН ХУВААРЬ ИРҮҮЛЭХ

6.1.Хуваарьт нислэгийн цагийн хуваарийг Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ийн Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба болон "НУБИЭ" ХХК хамтран боловсруулна.

6.2.Хуваарьт нислэгийн цагийн хуваарийг ОУАТХ/IATA/-оос гаргадаг "Олон улсын нислэгийн цагийн хуваарийг зохицуулах зааварчилгаа /Worldwide Airport Slot Guidelines/"-ны 8 дугаар бүлэг "Цагийн хуваарилалтын зарчмууд /Principles Of Slot Allocation/"-д үндэслэн, 10 дугаар бүлэг "Олон улсын Зохицуулах үйл явц /Worldwide Coordination And Facilitation Process", "Нислэгийн хуваарийн зохицуулалтын хуанли /CALENDAR OF COORDINATION ACTIVITIES/"-ийн дагуу гүйцэтгэнэ.

6.3.Зөвлөл нь агаарын тээвэрлэгчийн улирал тутмын нислэгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, дараагийн улирлын нислэгийн цагийн хуваарийн төлөвлөлтөд ашиглана.

6.4.Агаарын тээвэрлэгчид Олон улсын агаарын тээврийн холбоо /IATA/-ноос гаргадаг Нислэгийн хуваарийн зохицуулалтын хуанли /CALENDAR OF COORDINATION ACTIVITIES/-д заасан хугацаануудад багтаан нислэгийн цагийн хуваарийг Зөвлөл /atfm.slot@mcaa.gov.mn/-д хүргүүлж хамтран ажиллана.

6.5.Зөвлөл нь "Түүхэн нислэгийн жагсаалтыг хүргүүлэх эцсийн өдөр */Slot Historic List Message Deadline /To airlines by coordinators/*"-т багтаан агаарын тээвэрлэгчдэд тэдгээрийн түүхэн нислэгийн жагсаалтыг хүргүүлнэ.

6.6.Зөвлөл нь нисэх буудлын хүчин чадлын үзүүлэлтүүдийг "Түүхэн нислэгийг баталгаажуулах эцсийн өдөр */Agreed historics deadline/By airlines/*"-өөс хэтрүүлэхгүйгээр агаарын тээвэрлэгчдэд хүргүүлнэ.

6.7.Агаарын тээвэрлэгч нь "Түүхэн нислэгийг баталгаажуулах эцсийн өдөр */Agreed historics deadline /By airlines/*"-т багтаан түүхэн нислэгээ хүлээн зөвшөөрснөө Зөвлөлд мэдэгдэнэ.

6.8.Агаарын тээвэрлэгчид дараа улирлын нислэгийн хуваарийн саналаа "Улирлын нислэгийн хуваарийн саналаа хүргүүлэх эцсийн өдөр */Initial Submission Deadline/*"-нт багтаан Зөвлөл /atfm.slot@mcaa.gov.mn/-д хүргүүлнэ. Энэ хугацаанаас хойш ирүүлсэн саналыг хугацаандаа ирүүлсэн саналуудыг нэгтгэсний дараа авч үзэх ба агаарын тээвэрлэгчид нь нислэгийн цагийн хуваарийн саналаа хүргүүлэхээс өмнө нисэх буудлын хүчин чадлын үзүүлэлтүүдтэй бүрэн танилцсан байна.

6.9.Зөвлөл нь дараа улирлын нислэгийн цагийн хуваарийн саналыг нэгтгэн хуваарилсан цагийн хуваарийн төслийг агаарын тээвэрлэгчдэд хүргүүлэх эцсийн

өдөр */Slot Initial Allocation List Message Deadline /To airlines by coordinators/*"-т багтаан хүргүүлнэ.

6.10.Зөвлөл нь улирлын нислэгийн цагийн хуваарийн төслийн талаарх мэдээллийг агаарын тээвэрлэгчдэд хүргүүлэхээс өмнө агаарын тээвэрлэгчид болон бусад байгууллагуудад задруулахгүй байна.

6.11.Агаарын тээвэрлэгчид нь ашиглахгүй болсон нислэгийн цагийн хуваарийн талаарх мэдээллийг "Агаарын тээвэрлэгчид нь дараа улирлын нислэгийн цагийн хуваарийн төсөл дэх ашиглахгүй цагаа буцааж өгөх эцсийн өдөр */Series Return Deadline/*"-өөс өмнө Зөвлөлд мэдэгдэнэ.

6.12.Агаарын тээвэрлэгчид нь бүх нийтийн амралтын өдрүүдийн болон бусад шалтгаанаар цуцлах нислэгийн талаарх мэдээллийг "Түүхэн нислэгийг тогтоох суурь өдөр */Historics Baseline Date/Use-it or Lose-it Calculation/*"-өөс өмнө Зөвлөлд мэдэгдэнэ. Энэ хугацаа нь өвлийн нислэгийн улирлын хувьд тухайн улирал эхлэхээс өмнөх 08 дугаар сарын 31-ний өдөр, зуны нислэгийн улирлын хувьд тухайн улирал эхлэхийн өмнөх 01 дүгээр сарын 31-ний өдөр болно. Энэ нь хуваарьт нислэгийн цагаа ашиглаагүйгээс шалтгаалан нислэгийн гүйцэтгэлийн үр дүнг бууруулахаас сэргийлнэ.

6.13.Олон улсын болон орон нутгийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарьт 5 буюу түүнээс дээш тогтмол шинжтэй өөрчлөлт оруулах буюу нэмэгдэл нислэгийн хүсэлтийг тухайн нислэг эхлэхээс 7 хоногийн өмнө Зөвлөл /atfm.slot@mcaa.gov.mn/ -д Хавсралт 1-ийн дагуу цахимаар ирүүлнэ.

6.14.Нисэх буудалд засвар үйлчилгээ хийхтэй холбоотой зохицуулалт хийх хүсэлтийг Зөвлөлд тухай бүр ирүүлнэ.

6.15.Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдал үүссэний улмаас нисэх буудлуудын үйлчилгээг тодорхой хугацаанд хязгаарлах тохиолдолд хүсэлтийг Зөвлөлд тухай бүр ирүүлнэ.

7.ХАРИУЦЛАГА

7.1.Зөвлөлийн шийдвэрийг зөрчсөн агаарын тээвэрлэгч байгууллагын хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хуваарьт бус нислэг болгон өөрчлөх арга хэмжээ авна.

7.2.Зөвлөлөөр батлагдсан олон улсын болон орон нутгийн өвөл, зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийн дагуу 60 хоногийн хугацаанд нислэг үйлдээгүй агаарын тээвэрлэгчдийн батлагдсан хуваарьт нислэгийн цагийн хуваарийг мэдэгдэл өгөхгүйгээр шууд цуцална.

7.3.Агаарын тээвэрлэгчийн хуваарьт нислэгийн цагийн хуваарь тогтмолжоогүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чиглэл өөрчлөх, цуцлах, саатсан нислэгийн тоо тухайн чиглэлийн нийт нислэгийн 30 хувиас хэтэрсэн тохиолдолд дараагийн улирлын хуваарьт нислэгийн цагийн хуваарьт тухайн чиглэлийн нислэгийг оруулахгүй буюу хуваарьт бус болон нэмэгдэл нислэгийн цагийн хуваарьт хязгаарлалт хийж болно.

ХАВСРАЛТ 1

APPROVED BY .....

_____ AIRLINES INTERNATIONAL FLIGHT SCHEDULE
20 ... year (winter /summer)

No	Flight number	Aircraft type	Destination	Flight days	Departure time	Arrival time	Effective date

/UB time/

/for foreigner airlines/

БАТЛАВ .....

_____ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН
ОРОН НУТГИЙН ХУВААРЬТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ
20 ... оны өвөл/зуны

№	Аяллын дугаар	Агаарын хөлгийн маяг	Чиглэл	Гараг	Нисэх цаг	Буух цаг	Хүчинтэй хугацаа

/УБ цагаар/

/дотоодын агаарын тээвэрлэгч нар/

ХАВСРАЛТ 2

БАТЛАВ
ЦАГИЙН ХУВААРИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА /НЭР/

20 ... ОНЫ ЗУНЫ/ӨВЛИЙН УЛИРЛЫН ОЛОН УЛС/ОРОН НУТГИЙН ХУВААРЬТ НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ
(МӨРДӨХ ХУГАЦАА 20 ... ОНЫ .... ДУГААР САРЫН .... НААС 20 .... ОНЫ ... ДУГААР САРЫН ... НЫ ӨДӨР ХҮРТЭЛ)

Агаарын тээвэрлэгч, Агаарын хөлгийн маяг	Аяллын дугаар	Нислэгийн чиглэл	ДАВАА		МЯГМАР		ЛХАГВА		ПҮРЭВ		БААСАН		БЯМБА		НЯМ		Хүчинтэй хугацаа
			Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	Нисэх	Буух	

/УБ цагаар/

ТАНИЛЦСАН:

НЭГТГЭСЭН: